

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн шаардлага

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2015 онд цаазаар авах ялыг халах чиглэлээр, эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр, хүн амын эмзэг бүлгийн гишүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэл болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэл зэрэг нийт 12 төрлийн хүний эрхийг хамгаалах чиглэлийн зөвлөмжийг Монгол улсад өгсөн байдаг.

Тухайлбал үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлийн хүрээнд:

- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх;
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн харилцааг зохицуулсан хууль, журмуудад Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээсэн Монгол Улсын үүрэгт бүрэн дүүрэн нийцүүлэх, нэр төр гутаахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх асуудлыг судлан үзэх;
- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд болон иргэний нийгмийн зүтгэлтнүүд өөрсдийн үйл ажиллагааг олон улсын стандартад заасны дагуу шийтгэн цээрлүүлэх аливаа айдасгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоог хангах;
- Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцохгүй байх, төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах, эсхүл дарамт шахалтад орохоос хамгаалах орчныг бүрдүүлэх;
- Нэр төр гутаах үйлдлийг эрүүгийн гэмт хэргээс хасах, олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний хуулийн журмаар шийдвэрлэх;

зэрэг асуудлыг Монгол улс хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн.

Үүнтэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газар 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 204 дугаар тогтоолоор “НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г баталсан.

Уг төлөвлөгөөний 8 дугаар зүйлд “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр” эрүүгийн хуулийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоосон зүйл, заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх соёлыг бий болгох;

Сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалж болон шүгэлдэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүд мэргэжлийн чиг үүрэг, үйл ажиллагаагаа айх айдасгүй, эрх зүйн таатай орчинд явуулах;

Үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө аливаа дарамт шахалтад өртөхгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх зэргээр эрх зүйн орчинд шинэчлэл хийж, таатай орчныг бүрдүүлэх талаар ажил хийхээр төлөвлөсөн боловч НҮБ-ын өгсөн зөвлөмжийг өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж чадаагүй байна.

Харин эсрэгээрээ 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Худал мэдээлэл тараах” гэж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг шинэ заалтыг Эрүүгийн хуульд оруулсан олон улсад Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, мөн зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/III/ дугаар тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хүний эрхийн түгээмэл тунхаглал баталсан. Энэ олон улсын гэрээнд Монгол улс НҮБ-ын дүрэм болон бусад хэм хэмжээг зөвшөөрч, 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр гишүүнээр элссэн. Энэ тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээн авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.” гэж тунхагласан.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200 (XXI) тогтоолоор Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг баталж 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэ олон улсын гэрээнд Монгол улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Тус олон улсын гэрээний 19 дүгээр зүйлд “1.Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. 2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар, эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг

зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: а/бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; б/үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж заасан.

Дотоодын хууль тогтоомжийн хүрээнд Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;” мөн зүйлийн 17-т “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж зохицуулсан.

Олон улсын гэрээ болон Монгол улсын Үндсэн хуульд итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй байх эрхийн суурь зарчим болон үндэслэлийг хангалтай тусгаж зохицуулсан боловч Монгол улс материаллаг хууль болох Эрүүгийн хуульд дээрх олон улсын гэрээнүүдийн эсрэг зүйл баталсан байна.

1.2.Практик шаардлага

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар зүйлийн 13.14-т заасан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг 2020-2023 он, 2024 оны эхний 08 сарын хугацаанд нийт шалгасан 828 эрүүгийн хэргийн 548 буюу 66.2 хувийг шийдвэрлэсэн байна. 408 буюу 74.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж, 108 буюу 19.7 хувийг шүүхэд шилжүүлж, 32 буюу 5.8 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэж тус тус шийдсэн гэж Хууль зүй, дотоод хэргийн яамнаас танилцуулсан судалгаанаас харж болно.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т “... нэр төрийг нь доромжилж болохгүй...”, 17 дугаар зүйлийн 2-т “Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;” зэргээр хүний эрхийг хамгаалсан зохицуулалтыг тусгасан.

Өөрөөр хэлбэл үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн тохиолдолд Иргэний хуулийн 21 дүгээр зүйл болон 497 дугаар зүйлд заасан үндэслэлээр нөхөн сэргээж, гэм хороо хариуцан арилгах боломжтой байдлаар зохицуулсан.

Харамсалтай нь иргэний хуулийн дээрх зохицуулалтыг хуулийн давхардал үүсгэж эрүүгийн хуулиар давхардуулж зохицуулан алдаа гаргасан. Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг нэмэлтээр оруулсан энэ гэмт хэрэг нь “нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэж объектив талын шинжээр тодорхойлогдсон, 2002 оны Эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэргээс өргөн агуулга, хүрээтэй, шинэ хэв шинж бүхий гэмт хэрэг болжээ. Уг нэмэлтээр хууль

тогтоогч уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” гэж объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг бүрхэгдүүлэн, худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” зорилго, агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн гүйцэд тодорхойлолгүй орхигдуулж, нэр томьёо, ойлголтын зөрүүтэй байдал үүсгэсэн.

“Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй” гэсэн тайлбарыг хассан. Энэ нь хууль зүйн техникийг бүрэн бүрдүүлэх шаардлагыг алдагдуулан, хууль бүтээх ажиллагааны алдаа болсон буюу эрх зүйн хийдэл үүсгэсэн. Ингэснээр үг хэлэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн байдлыг дордуулан, өнөөдөр хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж байгаагийн гол шалтгаан болжээ гэж үзэх үндэстэй байна.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 14 дахь заалтын 1 дэх хэсгийг хасахаар зохицуулсан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын үндсэн хуульд заагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх хангагдах ач холбогдолтой.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.